

ГАРЧИГ	
НЭГ. ҮНДЭСЛЭЛ	87
ЗОРИЛГО	87
ЗОРИЛТ	87
ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖИЛТ АВЧ БАЙГАА ХУВИЙН ЭМНЭЛГҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	88
ГУРАВ. ДААТГУУЛАГЧИД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ХЭМЖЭЭ, 2016 ОНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ	90
ДӨРӨВ. ДААТГУУЛАГЧИД ҮЗҮҮЛЭХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДҮНГ ТӨРИЙН ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ТЭНЦҮҮ САНХҮҮЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ТӨСВИЙН ТООЦОО	91
ТАВ. ХУВИЙН ЭМНЭЛГҮҮД УЛСЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЧААЛАЛ ХУВААЛЦАХ БОЛОМЖ	91
ЗУРГАА. ДҮГНЭЛТ	93
Ашигласан материал, эх сурвалж:	94

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Хувийн ортой эмнэлгүүдийн тоо, 2016 оны байдлаар

Хүснэгт 2. Хувийн ортой эмнэлгүүдийн хэвтэн эмчлүүлэгчдийн хувь, 2016 он

Хүснэгт 3. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын тоо, 2016 он

Хүснэгт 4. Даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээ

Зургийн жагсаалт

Зураг 1. Хувийн эмнэлгийн амбулаторийн үзлэгийн тоо, 2005-2016 он

Зураг 2. Хувийн эмнэлгүүдийн үйл ажиллагааны чиглэл

Зураг 3. Эрүүл мэндийн даатгалын сангаас хувийн хэвилийн эмнэлэгт 2016 онд олгосон санхүүжилт

Зураг 4. Хувийн хэвилийн эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хувьсах зардлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн тооцоо

Зураг 5. Төрийн өмчийн болон хувийн эмнэлгүүдийн орны ашиглалт, тасгаар

Зураг 6. Төрийн өмчийн болон хувийн эмнэлгүүдийн орны ашиглалт, тасгаар

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр эрүүл мэндийн салбарт зарцуулах улсын төсвийн зардал эрс багассан ч хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүрсэн түвшинг бууруулахгүйгээр хөгжүүлэх, иргэдийг эрүүл мэндийн улмаас үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах, тусламж үйлчилгээг тэгш хүргэхийн тулд УИХ-аас 1993 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг баталж, 1994 оноос хэрэгжүүлж эхэлсэн¹.

Эрүүл мэндийн нийгмийн даатгалыг “Эрүүл мэнд нь нийгмийн үнэт зүйл учраас зах зээлийн бүтээгдэхүүнээс ангид авч үздэг байх ёстой” гэсэн үзэл баримтлалаас урган гарсан гэж үздэг. Хүн амд түгээмэл тохиолддог нийгмийн эрсдэлийн нэг нь “өвчлөл” байдаг. Энэхүү эрсдэлээс хамгаалах нийгмийн хамгааллын арга хэрэгсэл нь “эрүүл мэндийн даатгал” юм.

Эрүүл мэндийн нийгмийн даатгал нь нийгэмд тэгш байдлыг хөхиүлэн дэмжих замаар эв санааны нэгдлийг бий болгох зорилго бүхий орчин үеийн нийгэм, эдийн засгийн хөтөлбөр юм. Эрүүл мэндийн даатгалын сан нь эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагын сонгон шалгаруулдаг тэнцсэн, магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг сувилалтай гэрээ байгуулж оношийн хамааралтай бүлгээр төлбөр хийх аргаар санхүүжүүлдэг.

Оношийн хамааралтай бүлгээр төлбөр хийх арга нь өвчнийг эмчилгээний арга хэрэгслийн ижил төстэй байдлаар нь бүлэглэн, тухайн бүлэгт орсон өвчин эмгэгийг эмчлэхэд ижил хэмжээний нөөц зарцуулахаар тооцсон арга юм. Гэвч Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар энэхүү ижил хэмжээний нөөц зарцуулахаар тооцсон төлбөрийн арга хэрэглэж байгаа боловч улсын эмнэлэг, хувийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн төлбөрийг ялгаатай тарифаар санхүүжүүлж байна.

Хувийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг ижил тарифаар санхүүжүүлэхгүй байгаа нь улсын эмнэлгүүдийн ачааллыг нэмэгдүүлж, хувийн эмнэлгүүдийн ор хоногийн тарифыг өндөр болгож, иргэдэд ирэх санхүүгийн дарамтыг улам нэмэгдүүлж байна. Иймд улсын болон хувийн эмнэлгүүдэд ижил тарифаар санхүүжүүлэх хэрэгцээ байгаа нь судалгааны үндэслэл болж байна.

ЗОРИЛГО

Даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээнд улсын болон хувийн эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний санхүүжилтийг ижил тарифтай болгоход шаардлагатай санхүүжилтийг тооцох, шийдвэр гаргачдыг үндэслэл нотолгоогоор хангах

ЗОРИЛТ

- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2016 оны хувийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлсэн зардал болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний ачааллыг судлах
- Ижил тарифаар санхүүжүүлэхэд шаардлагатай төсвийг тооцох

¹ Эрүүл мэндийн нийгмийн даатгал, 2017 он, Ц.Ганцэцэг

ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖИЛТ АВЧ БАЙГАА ХУВИЙН ЭМНЭЛГҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2016 оын байдлаар 234 ортой, 1 076 үүдэн хувийн эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хувийн эмнэлгүүдэд 2 935 их эмч, 2 046 сувилагч, нийт 8 730 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна.

Хүснэгт 1. Хувийн ортой эмнэлгүүдийн тоо, 2016 оны байдлаар

	2000	2005	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Ортой эмнэлгийн тоо	466	160	160	166	171	179	197	202	224	234
Үүдэн эмнэлгийн тоо		523	922	947	1013	851	822	969	1 006	1 076
Эмнэлгийн орны тоо	964	1 982	2 422	2 527	3 069	3 606	3 829	4 542	5 262	5 611
Нийт оронд эзлэх хувь	5.4	10.8	13.6	14.2	16.2	18.4	19.3	22.1	24.2	24.4
Эмчийн тоо	736	1 145	1 396	1 549	1 677	1 904	1 965	2 368	2 698	2 935
Сувилагч	296	682	858	1 007	1 135	1 275	1 326	1 742	1 941	2 046
Эмнэлэгт хэвтсэн хүний тоо	23 592	63 267	75 003	86 117	97 821	111 338	121 452	124 610	142 052	159 194
Дундаж ор хоног	11.3	9.0	8.1	7.9	8.2	7.7	7.4	7.3	7.0	7.2

Эх үүсвэр: ЭМХТөвийн Эрүүл мэндийн үзүүлэлт-2016

Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн орны тоо 2005 онд 1 982 байсан бол 2016 онд 5 611 болж нэмэгдсэн бөгөөд нийт эмнэлгийн орны 24.4 хувийг эзэлж байна. 2005 оноос хувийн эмнэлгүүдийг ялангуяа ортой эмнэлгийг шинээр байгуулахыг хязгаарлах, харин улсын эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэх, төрөлжүүлэх бодлогыг хэрэгжүүлж ирсэн билээ.

Эмнэлгийн орны нийт оронд эзлэх хувь 2000 онд 5.4 хувь байсан бол 2016 онд 24.4 хувь болж өссөн байна.


Зураг 7. Хувийн эмнэлгийн амбулаторийн үзлэгийн тоо, 2005-2016 он



Эх үүсвэр: ЭМХТөвийн Эрүүл мэндийн үзүүлэлт-2016

Хувийн хэвшлийн эмнэлгүүдээр 2005 онд 1 016 705 хүн амбулаториор үйлчлүүлж, 63 267 хүн хэвтэн эмчлүүлж байсан бол 2016 онд амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо 2 063 450, хэвтэн эмчлүүлэгчийн тоо 159 194 болж нэмэгдсэн байна. Давхардсан тоогоор хувийн эмнэлгүүдээр иргэд маш ихээр үйлчлүүлдэг болсон байна.

Зураг 8. Хувийн эмнэлгүүдийн үйл ажиллагааны чиглэл



2016 оны байдлаар хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн 41.2 хувь нь дотор, 11.4 хувь нь мэдрэл, 13.7 хувь нь уламжлалт, 8.1 хувь нь эмэгтэйчүүд, 6.4 хувь нь мэс засал, 5.1 хувь нь хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 2. Хувийн ортой эмнэлгүүдийн хэвтэн эмчлүүлэгчдийн хувь, 2016 он

Үзүүлэлт	Эмнэлгийн тоо		Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
5-8 ортой	15	6.4	2 445	1.6
10-12 ортой	60	25.6	19 627	12.3
15 ортой	39	16.7	18 012	11.3
20-25 ортой	59	25.2	36 178	22.7
30 ортой	22	9.4	17 915	11.3
40-50 ортой	22	9.4	21 501	13.5
50 ба түүнээс дээш ортой	17	7.3	43 516	27.3
Нийт дүн	234	100.0	159 194	100.0

Эх үүсвэр: ЭМХТөвийн Эрүүл мэндийн үзүүлэлт-2016

Хувийн хэвшлийн эмнэлгүүдийг орны хүчин чадлаар ангилж үзвэл 5-8 ортой эмнэлэг 6.4 хувийг, 10-12 ортой эмнэлэг 25.6 хувийг, 15 ортой эмнэлэг 16.7 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд хувийн эмнэлгийн 48.7 хувь нь 15 хүртэлх ортой эмнэлгүүд байна.

Ортой хувийн хэвшлийн эмнэлгүүд 2006 оноос эрүүл мэндийн даатгалын санхүүжилт авч эхэлсэн бөгөөд магадлан итгэмжлэгдсэн 171 эмнэлэг эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулан даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг оношийн хамааралтай бүлгээр, өртгийн жингээр тооцон авч байна.

Хүснэгт 3. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын тоо, 2016 он

№	Эрүүл мэндийн байгууллагын төрөл	Тоо
1	Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв	13
2	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв	5
3	Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв	28
4	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, сумын эмнэлэг, эрүүл мэндийн төв	57
5	Хувийн хэвшлийн эмнэлэг	171
6	Рашаан сувилал	44
7	Эмийн сан	785
	Бүгд	1 103

Эх сурвалж: ЭМНДЕГ, 2017

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авдаг ортой хувийн эмнэлэг 171 эмнэлэг байна.

ГУРАВ. ДААТГУУЛАГЧИД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ХЭМЖЭЭ, 2016 ОНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ

Эрүүл мэндийн даатгалын сангийн даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний хувьсах зардлын хэмжээ

Даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээг Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2013 оны 12 сарын 09-ны өдрийн 459/280/182 тушаалаар баталсан.

Хүснэгт 4. Даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээ

№	Тусламж үйлчилгээний төрөл	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага	Хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллага
1	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	300 000	175 000
2	Өдрөөр эмчлэх тусламж, үйлчилгээ	135 000	0
3	Амбулаторийн тусламж, үйлчилгээ	15 000	0
4	Оношлогоо шинжилгээ	55 000	0
5	Уламжлалт эмчилгээ	117 000	117 000
6	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	110 000	110 000
7	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	300 000	175 000
8	Дараалсан 3 жилийн хугацаанд тусламж, үйлчилгээний зардал гаргаагүй даатгуулагчийг нэг удаа эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулах үйлчилгээ	80 000	80 000

Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний 125 000, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ 125 000 төгрөгийн зөрүүтэй байгаа бол өдрөөр эмчлэх тусламж, үйлчилгээ, амбулаторийн тусламж, үйлчилгээ, оношлогоо, шинжилгээг хувийн эмнэлэгт огт санхүүжүүлдэггүй байна.

Эрүүл мэндийн даатгалын сан нь өртөг ойролцоо оношийн бүлгээр даатгуулагчид үзүүлэх хувьсах зардлын хэмжээг гарган өртгийн жингээр үржүүлж санхүүжилтийг олгодог. Өртгийн жин нь тухайн оношуудын орцын зардлыг тооцож хувьсах зардлын хэмжээгээр тохируулга хийсэн дүн байдаг. Улсын эмнэлэг, хувийн эмнэлгийн өртгийн жин хэт өндөр хэлбэлзэлтэй байх магадлал бага. Иймд хувийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа иргэд энэхүү зөрүү болон тухайн байгууллагын ашгийн хувийг хувиасаа төлж байна. Энэ нь эргээд даатгуулагчдад эрүүл мэндээс шалтгаалсан эдийн засгийн дарамт болж байна.

Зураг 9. Эрүүл мэндийн даатгалын сангаас хувийн хэвшлийн эмнэлэгт 2016 онд олгосон санхүүжилт

№	Хэлтсүүд	Хэвтэн эмчлүүлсэн		Уламжлал		Амбулатори		Өдрийн эмчилгээ		Оношлогоо		Хөнгөвчлөх		Нийт			
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн		
1	Архангай	2,822	476,962,172											2,822	476,962,172		
2	Баян-Өлгий	3,271	559,371,300	66	7,722,000	1,433	414,545,500	289,285,07						4,770	981,638,800		
3	Баянхонгор	2,800	471,485,571											2,800	471,485,571		
4	Булган	1,555	256,378,677	710	83,070,000	117,000								2,265	339,448,677		
5	Говь-Алтай	1,092	185,095,368											1,092	185,095,368		
6	Дорноговь	1,066	163,780,194											1,066	163,780,194		
7	Дорнод	1,973	327,803,003											1,973	327,803,003		
8	Дундговь	917	157,582,841											917	157,582,841		
9	Завхан	1,385	212,114,096											1,385	212,114,096		
10	Өвөрхангай	3,470	569,654,357	142	16,614,000	117,000								3,612	586,268,357		
11	Өмнөговь	904	145,092,300											904	145,092,300		
12	Сүхбаатар	1,021	157,800,336											1,021	157,800,336		
13	Сэлэнгэ	3,237	512,772,848											3,237	512,772,848		
14	Төв	541	86,486,847											541	86,486,847		
15	Увс	1,764	284,309,706											1,764	284,309,706		
16	Ховд	2,194	363,603,500	339	39,572,000	116,732								2,533	403,175,500		
17	Хөвсгөл	4,978	838,121,124	547	63,999,000	117,000								5,525	902,120,124		
18	Хэнтий	1,084	173,817,900	56	6,552,000	117,000								1,140	180,369,900		
19	Дархан-Уул	8,583	1,447,982,613	1,764	206,388,000	117,000								10,347	1,654,370,613		
20	Орхон	3,010	506,123,289	936	109,512,000	117,000								3,946	614,635,289		
21	Говьсүмбэр													-	-		
22	Нийслэл	152	27,167,929											152	27,167,929		
	Ерөнхий газар	99,388	20,170,784,982	4,836	563,940,000	116,613	54,561	846,316,200	15,511,38	2,517	320,834,165	28,408	963,817,183	2	220,000	189,712	22,865,912,530
	Нийт	147,207	28,093,290,953	9,396	1,097,369,000	116,791	55,994	1,260,861,700	22,517,80	2,517	320,834,165	28,408	963,817,183		243,522	31,736,173,001	

Нийт 2016 оны байдлаар 31 тэрбум 736 сая төгрөгийн хувийн эмнэлэгт зарцуулаад байна. Ерөнхий газар дээр гэрээ хийсэн эмнэлгүүд 22 тэрбум, 855 сая төгрөгийн санхүүжилт авч хамгийн өндөр санхүүжилтийг авсан байна. Аймгуудаас хамгийн өндөр санхүүжилтийг Дархан-Уул аймаг 10 347 хүн хэвтэн эмчлүүлж, 1 тэрбум 654 сая төгрөг авдаг бол хамгийн бага Төв аймаг 541 хүн хэвтэн эмчлүүлж, 86 сая, 485 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

ДӨРӨВ. ДААТГУУЛАГЧИД ҮЗҮҮЛЭХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДҮНГ ТӨРИЙН ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ТЭНЦҮҮ САНХҮҮЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ТӨСВИЙН ТООЦОО

Зураг 10.. Хувийн хэвшлийн эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хувьсах зардлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн тооцоо

№	Аймаг, нийслэлийн нэр	Хувийн хэвшлийн эмнэлэг		Дундаж санхүүжилт /175,000 төгрөгийн тарифаар/	Оношийн кодын өртгийн жин	Дундаж санхүүжилт /300,000 төгрөгийн тарифаар/		Хувийн эмнэлгийн тарифыг 300,000 төгрөг болгоход шаардлагатай санхүүжилт	Нэмэгдэх санхүүжилтийг хувиар авч үзвэл			
		Хэвтэн эмчлүүлсэн				Нэг иргэний авсан дундаж санхүүжилт	Оношийн өртгийн жин ойролцоогоор			Нэг иргэний авах дундаж санхүүжилт	Тогтмол тарифыг нэмэгдүүлэхэд гарах санхүүжилтийн дүн	Нэг жилд нэмэгдэх санхүүжилтийн дүн
		Хүний тоо	Санхүүжилтийн дүн									
		1	2									
1	Архангай	2,822	476,962,172	169,015.65	0.97	289,741.12	817,649.438	340,687,266	71%			
2	Баян-Өлгий	4,770	981,638,800	205,794.30	0.98	293,158.74	1,398,367.175	416,728,375	71%			
3	Баянхонгор	2,800	471,485,571	168,387.70	0.96	288,664.64	808,260.979	336,775,408	71%			
4	Булган	2,265	339,448,677	149,866.97	0.94	282,640.71	640,181,207	300,732,530	71%			
5	Говь-Алтай	1,092	185,095,368	169,501.25	0.97	290,573.58	317,306,345	132,210,977	71%			
6	Дорноговь	1,066	163,780,194	153,639.96	0.88	263,382.78	280,766,047	116,985,853	71%			
7	Дорнод	1,973	327,803,003	166,144.45	0.95	284,819.06	561,948,005	234,145,002	71%			
8	Дундговь	917	157,582,841	171,846.06	0.98	294,593.25	270,142,013	112,559,172	71%			
9	Завхан	1,385	212,114,096	153,150.97	0.88	262,544.52	363,624,165	151,510,069	71%			
10	Өвөрхангай	3,612	586,268,357	162,311.28	0.94	281,426.61	1,016,512,904	430,244,547	71%			
11	Өмнөговь	904	145,092,300	160,500.33	0.92	275,143.43	248,729,657	103,637,357	71%			
12	Сүхбаатар	1,021	157,800,336	154,554.69	0.88	264,950.89	270,514,862	112,714,526	71%			
13	Сэлэнгэ	3,237	512,772,848	158,409.90	0.91	271,559.83	879,039,168	366,266,320	71%			
14	Төв	541	86,486,847	159,864.78	0.91	274,053.91	148,263,166	61,776,319	71%			
15	Увс	1,764	284,309,706	161,173.30	0.92	276,297.09	487,388,067	203,078,361	71%			
16	Ховд	2,533	403,175,500	159,169.17	0.95	284,102.23	719,630,941	316,455,441	71%			
17	Хөвсгөл	5,525	902,120,124	163,279.66	0.96	288,625.77	1,594,657,364	692,537,240	71%			
18	Хэнтий	1,140	180,369,900	158,219.21	0.92	274,883.34	313,367,010	132,997,110	71%			
19	Дархан-Уул	10,347	1,654,370,613	159,888.92	0.96	289,206.09	2,992,415,458	1,338,044,845	71%			
20	Орхон	3,946	614,635,289	155,761.60	0.96	287,682.94	1,135,196,867	520,561,578	71%			
21	Говьсүмбэр	-	-	-	-	-	-	-	#DIV/0!			
22	Нийслэл	152	27,167,929	178,736.38	1.02	306,405.21	46,573,593	19,405,664	71%			
	Ерөнхий газар	189,712	22,865,912,530	120,529.61	1.16	347,914.12	66,003,483,499	43,137,570,969	71%			
	Нийт	243,522	31,736,173,001	3,559,746	21	6,272,370	81,314,017,931	49,577,624,930				

2016 онд хувийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газар, хэлтсүүдтэй гэрээтэй эмнэлгүүдээр 243 522 хүн хэвтэн эмчлүүлж 31 тэрбум 736 сая төгрөгийн санхүүжилтийг 2016 он байдлаар авч байна. Даатгуулагчдад үзүүлэх хувьсах зардлын дүнг 125 000 төгрөгөөр нэмэгдүүлэхэд хэвтэн эмчлүүлэгчийн тоог тогтмол байна гэж үзвэл 81 тэрбум 314 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай болж 50 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэж, даатгалын сан дээр ачаалал ирнэ гэж тооцоолж байна.

Улсын эмнэлэгтэй ижил 300 000 төгрөгөөр санхүүжүүлэхэд хувийн эмнэлгүүдэд олгодог санхүүжилтийг 71 хувиар нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ТАВ. ХУВИЙН ЭМНЭЛГҮҮД УЛСЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЧААЛАЛ ХУВААЛЦАХ БОЛОМЖ

Хувийн эмнэлгийн санхүүжилтийг 71 хувиар нэмэгдүүлснээр улсын эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний ачаалал тодорхой хувиар буурна гэж үзэж байна. 2016 оны байдлаар улсын болон хувийн эмнэлгүүдийн орны ачаалал ямар байсныг доорх тооцоолуудаар үзсэн.

Зураг 11. Төрийн өмчийн болон хувийн эмнэлгүүдийн орны ашиглалт, тасгаар

Эрүүл мэндийн байгууллагууд	М/д	Эмнэлгийн тасгаар											
		Нефролог	Уролог	Эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах	Нүд	Чих, хамар хоолой	Эрүү нүүр	Хавдар	Уламжлалт эмчилгээ	Хөнгөвчлөх эмчилгээ	Бусад	Бүгд	
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
Орны тоо	Бүгд	1	154.0	66.0	309.0	138.0	171.0	67.0	181.0	628.0	131.0	403.0	2,540.0
	Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүү	2	115.0	66.0	92.0	78.0	86.0	48.0	126.0	146.0	26.0	3.0	763.0
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	3	-	-	104.0	54.0	75.0	39.0	55.0	132.0	91.0	138.0	735.0
	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	4	-	-	2.0	-	-	-	-	10.0	3.0	-	12.0
	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	5	-	-	70.0	-	-	-	-	42.0	4.0	-	112.0
	Сум дундын эмнэлэг	6	-	-	-	-	-	-	-	6.0	-	-	6.0
	Сум, тосгоны эмнэлэг	7	-	-	-	-	-	-	-	24.0	7.0	5.0	34.0
	Бусад эмнэлэг	9	39.0	-	41.0	6.0	10.0	-	-	268.0	-	257.0	878.0
	Хувийн эмнэлэг	8	-	5.0	40.0	99.0	75.0	-	8.0	770.0	85.0	96.0	1,189.0
Ор хонгог	Бүгд	10	46,361.0	21,455.0	59,587.0	32,106.0	48,562.0	22,247.0	57,710.0	190,794.0	20,137.0	85,225.0	584,194.0
	Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүү	11	36,004.0	21,455.0	25,718.0	20,642.0	28,989.0	15,086.0	42,802.0	47,184.0	8,002.0	156.0	238,192.0
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	12	-	-	10,297.0	10,177.0	17,013.0	7,161.0	14,908.0	39,358.0	11,152.0	29,879.0	158,672.0
	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	13	-	-	85.0	-	-	-	-	298.0	154.0	-	383.0
	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	14	-	-	15,711.0	-	-	-	-	12,066.0	829.0	-	27,777.0
	Сум дундын эмнэлэг	15	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Сум, тосгоны эмнэлэг	16	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Бусад эмнэлэг	18	10,357.0	-	7,776.0	1,287.0	2,560.0	-	-	91,888.0	-	55,190.0	224,248.0
	Хувийн эмнэлэг	17	-	2,238.0	2,940.0	11,708.0	22,911.0	-	372.0	114,800.0	14,067.0	21,722.0	198,413.0
Хэвтэн эмчлүүлсэн хүний тоо	Бүгд	19	5,163.0	3,485.0	4,181.0	5,780.0	7,170.0	4,154.0	7,683.0	22,637.0	2,646.0	11,022.0	73,921.0
	Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүү	20	4,044.0	3,485.0	969.0	4,174.0	4,505.0	3,076.0	5,841.0	6,237.0	1,076.0	39.0	32,409.0
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	21	-	-	1,539.0	1,459.0	2,352.0	1,078.0	1,842.0	4,640.0	1,456.0	4,623.0	22,156.0
	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	22	-	-	11.0	-	-	-	-	31.0	18.0	-	42.0
	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	23	-	-	1,395.0	-	-	-	-	1,473.0	96.0	-	2,868.0
	Сум дундын эмнэлэг	24	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Сум, тосгоны эмнэлэг	25	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Бусад эмнэлэг	27	1,119.0	-	267.0	147.0	313.0	-	-	10,256.0	-	6,360.0	101,171.0
	Хувийн эмнэлэг	26	-	415.0	273.0	2,947.0	4,109.0	-	114.0	14,265.0	1,677.0	3,039.0	159,194.0
ОФӨ	Бүгд	28	301.0	325.1	192.8	232.7	284.0	255.7	318.8	303.8	153.7	211.5	230.0
	Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүү	29	313.1	325.1	279.5	264.6	337.1	314.3	339.7	323.2	307.8	52.0	312.2
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	30	-	-	99.0	188.5	226.8	183.6	271.1	298.2	122.5	216.5	215.9
	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	31	-	-	42.5	-	-	-	-	29.8	51.3	-	31.9
	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	32	-	-	224.4	-	-	-	-	287.3	207.3	-	248.0
	Сум дундын эмнэлэг	33	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Сум, тосгоны эмнэлэг	34	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Бусад эмнэлэг	36	265.6	-	189.7	214.5	256.0	-	-	342.9	-	214.7	255.4
	Хувийн эмнэлэг	35	-	447.6	73.5	118.3	305.5	-	46.5	149.1	165.5	226.3	166.9
ОФӨ %	Бүгд	37	89.6	96.7	57.4	69.2	84.5	76.1	94.9	90.4	45.7	62.9	68.5
	Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүү	38	93.2	96.7	83.2	78.8	100.3	93.5	101.1	96.2	91.6	15.5	92.9
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	39	-	-	29.5	56.1	67.5	54.6	80.7	88.7	36.5	64.4	64.3
	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	40	-	-	12.6	-	-	-	-	8.9	15.3	-	9.5
	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	41	-	-	66.8	-	-	-	-	85.5	61.7	-	73.8
	Сум дундын эмнэлэг	42	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Сум, тосгоны эмнэлэг	43	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Бусад эмнэлэг	45	79.0	-	56.4	63.8	76.2	-	-	102.0	-	63.9	76.0
	Хувийн эмнэлэг	44	-	133.2	21.9	35.2	90.9	-	13.8	44.4	49.3	67.3	49.7

Орны фонд ашиглалтыг хувиар тасгуудаар харвал чих, хамар хоолойн тасаг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 100.0 хувь, аймгийн нэгдсэн эмнэлэгт 67.5 хувь, бусад эмнэлэгт 76.2 хувь, хувийн эмнэлэгт 90.9 хувийн ачаалалтай байна. Уламжлалт эмчилгээ улсын эмнэлгүүдэд 90.4 хувь, хувийн эмнэлэгт 44.4 хувийн ачаалалтай байна. Хавдрын орны фонд ашиглалтын хувь улсын эмнэлэгт дундаж нь 94.9 байгаа бол хувийн эмнэлэгт 13.8 хувьтай байна. Хувийн эмнэлгүүдэд урологийн тасгийн батлагдсан орны багтаамжийг 33.2 хувиар нэмэгдүүлж хүн хэвтүүлэн эмчилж байна.

Дээрх хүснэгтэд байгаа тасгуудаас харахад нефролог, эрүү нүүрний тасгийн орнууд хувийн эмнэлгүүдэд байдаггүй байна.

Зураг 12. Төрийн өмчийн болон хувийн эмнэлгүүдийн орны ашиглалт, тасгаар

Эрүүл мэндийн байгууллагууд	м/д	Эмнэлгийн тасгаар												
		Дотор	Мэс засал	Төрөх	Эмэгтэйчүүд	Хүүхэд	Халдварт	Арьс харшил	Сүрьеэ	Мэдрэл	Сэтгэц	Гэмтэл	Бүгд	
A	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Орны тоо	Бүгд	1	4,698.0	1,169.0	1,744.0	687.0	2,559.0	1,056.0	342.0	520.0	945.0	719.0	642.0	15,081.0
	Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүү	2	550.0	399.0	175.0	96.0	147.0	330.0	168.0	200.0	187.0	500.0	400.0	3,151.0
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	3	903.0	444.0	571.0	303.0	712.0	308.0	133.0	253.0	414.0	217.0	206.0	4,464.0
	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	4	142.0	61.0	40.0	28.0	76.0	29.0	-	6.0	13.0	2.0	-	397.0
	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	5	941.0	39.0	42.0	22.0	740.0	33.0	7.0	6.0	222.0	-	-	2,052.0
	Сум дундын эмнэлэг	6	274.0	72.0	99.0	48.0	161.0	58.0	-	-	-	-	-	712.0
	Сум, тосгоны эмнэлэг	7	1,359.0	24.0	407.0	41.0	667.0	298.0	-	-	-	-	-	2,796.0
	Бусад эмнэлэг	9	529.0	130.0	410.0	150.0	56.0	-	-	34.0	55.0	109.0	-	1,509.0
	Хувийн эмнэлэг	8	2,311.0	357.0	53.0	452.0	288.0	-	-	78.0	-	642.0	42.0	210.0
Ор хонго	Бүгд	10	1,581,657.0	308,521.0	395,638.0	166,060.0	822,823.0	211,559.0	93,450.0	114,475.0	329,435.0	234,145.0	213,191.0	4,470,954.0
	Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүү	11	177,501.0	120,467.0	65,343.0	26,070.0	51,938.0	90,085.0	50,750.0	51,454.0	68,703.0	184,029.0	139,082.0	1,025,422.0
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	12	311,794.0	115,548.0	151,688.0	81,322.0	248,920.0	83,969.0	31,877.0	59,177.0	136,479.0	50,084.0	60,681.0	1,331,539.0
	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	13	45,346.0	13,430.0	9,134.0	6,649.0	26,847.0	5,569.0	-	1,655.0	6,796.0	32.0	-	115,458.0
	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	14	315,309.0	9,642.0	11,918.0	5,506.0	288,088.0	6,175.0	469.0	2,189.0	77,647.0	-	-	716,943.0
	Сум дундын эмнэлэг	15	88,444.0	7,190.0	5,489.0	8,039.0	32,891.0	4,736.0	-	-	-	-	-	146,769.0
	Сум, тосгоны эмнэлэг	16	475,874.0	2,381.0	11,948.0	5,793.0	159,105.0	21,025.0	-	-	-	-	-	678,126.0
	Бусад эмнэлэг	18	167,389.0	39,863.0	140,138.0	32,681.0	15,034.0	-	-	-	-	-	-	458,697.0
	Хувийн эмнэлэг	17	533,059.0	58,057.0	6,278.0	70,068.0	61,344.0	-	-	8,838.0	-	168,630.0	3,337.0	42,052.0
Хавтан амчлуулсан хүний тоо	Бүгд	19	199,070.0	48,979.0	105,604.0	25,587.0	126,836.0	28,128.0	10,175.0	4,132.0	38,353.0	11,170.0	22,809.0	620,943.0
	Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүү	20	22,367.0	18,351.0	15,311.0	4,113.0	4,571.0	12,189.0	5,402.0	1,915.0	8,094.0	6,278.0	14,002.0	112,593.0
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	21	33,866.0	20,600.0	34,816.0	13,272.0	34,354.0	10,539.0	3,570.0	2,112.0	15,346.0	4,888.0	7,359.0	180,722.0
	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	22	4,911.0	2,002.0	1,832.0	1,066.0	3,887.0	796.0	-	54.0	748.0	4.0	-	15,300.0
	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	23	41,189.0	1,381.0	2,386.0	709.0	49,837.0	936.0	57.0	51.0	10,071.0	-	-	106,617.0
	Сум дундын эмнэлэг	24	11,874.0	1,230.0	1,539.0	1,242.0	5,391.0	657.0	-	-	-	-	-	21,933.0
	Сум, тосгоны эмнэлэг	25	66,607.0	325.0	3,588.0	906.0	26,527.0	3,011.0	-	-	-	-	-	100,964.0
	Бусад эмнэлэг	27	18,256.0	5,090.0	46,132.0	4,279.0	2,269.0	-	-	-	-	-	-	82,714.0
	Хувийн эмнэлэг	26	70,863.0	11,333.0	1,864.0	11,230.0	10,649.0	-	-	1,144.0	-	20,688.0	670.0	3,916.0
ОБА	Бүгд	28	336.7	263.9	226.9	241.7	321.5	200.3	273.2	220.1	349.6	325.7	332.1	296.5
	Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүү	29	322.7	301.9	373.4	274.4	353.3	273.0	302.1	257.3	367.4	368.1	347.7	325.4
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	30	345.3	260.2	265.7	268.4	349.6	272.6	239.7	233.9	329.7	230.8	294.6	298.3
	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	31	319.3	220.2	228.4	237.5	353.3	192.0	-	275.8	522.8	16.0	-	290.8
	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	32	335.1	247.2	228.8	250.3	389.3	187.1	67.0	364.8	349.8	-	-	349.4
	Сум дундын эмнэлэг	33	322.8	99.9	55.2	167.5	204.3	81.7	-	-	-	-	-	206.1
	Сум, тосгоны эмнэлэг	34	350.2	99.2	29.4	141.3	238.5	70.6	-	-	-	-	-	241.8
	Бусад эмнэлэг	36	316.4	306.6	341.8	217.9	268.5	-	-	304.5	-	365.2	-	373.0
	Хувийн эмнэлэг	35	230.7	162.6	118.5	155.0	213.0	-	-	113.3	-	262.7	79.5	200.2
ОБА %	Бүгд	37	100.0	78.5	67.5	71.9	95.7	59.6	81.3	65.5	103.8	96.9	98.8	88.2
	Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүү	38	96.1	89.9	111.1	81.7	105.2	81.2	89.9	76.6	109.3	109.5	103.5	96.9
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	39	102.8	77.5	79.1	79.9	104.0	81.1	71.3	89.6	98.1	88.7	87.7	88.8
	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	40	95.0	65.5	68.0	70.7	105.1	57.2	-	82.1	155.6	4.8	-	86.6
	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	41	99.7	73.6	84.5	74.5	115.9	55.7	19.9	108.6	104.1	-	-	104.0
	Сум дундын эмнэлэг	42	96.1	29.7	16.4	49.8	60.8	24.3	-	-	-	-	-	61.4
	Сум, тосгоны эмнэлэг	43	104.2	29.5	8.7	42.1	71.0	21.0	-	-	-	-	-	72.0
	Бусад эмнэлэг	45	94.2	91.3	101.7	64.8	79.9	-	-	90.6	-	108.7	-	111.0
	Хувийн эмнэлэг	44	68.6	46.4	35.3	46.1	63.4	-	-	33.7	-	78.2	23.6	59.6

Улсын эмнэлгүүдэд дотрын тасгийн орны фонд ашиглалтын хувь 100.0 хувь байгаа бол хувийн эмнэлгүүдэд 68.6 хувь байна. Хүүхдийн тасаг улсын эмнэлэгт 95.7 хувьтай, улсын эмнэлэгт 63.4 хувийн орны фонд ашиглалттай байна. Мэдрэлийн тасгийн орны фонд ашиглалтын хувь улсын эмнэлгүүдэд 100.0 хувь байгаа бол хувийн эмнэлэгт 78.2 хувь байна. Сэтгэцийн эмнэлгийн орны фонд ашиглалтын хувь улсын эмнэлэгт 96.9 хувь, хувийн эмнэлэгт 23.6 хувь байна. Гэмтлийн орны фонд ашиглалтын хувь улсын эмнэлгүүдэд 98.8 хувь байгаа бол хувийн эмнэлэгт 59.6 хувьтай байна.

Хувийн эмнэлгүүдэд халдварт, сүрьеэгийн тасаг нийлж байддаггүй байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын болон хувийн эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг ижил тарифаар санхүүжүүлснээр мэдрэл, дотор, хүүхэд, чих, хамар хоолой, уламжлалтын тасгуудын ачааллаас 15-35 хувь хүртэл ачааллыг хуваалцах боломжтой байна.

ЗУРГАА, ДҮГНЭЛТ

1. Хувийн хэвшлийн эмнэлгүүдэд 2016 оны байдлаар 31 тэрбум 736 сая төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон байна.
2. Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын болон хувийн эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг ижил тарифаар санхүүжүүлснээр мэдрэл, дотор, хүүхэд, чих, хамар хоолой, уламжлалтын тасгуудын ачааллаас 15-35 хувь хүртэл ачааллыг хуваалцах боломжтой байна.
3. Хувийн болон улсын эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг санхүүжүүлснээр жилд 50.0 тэрбум төгрөг нэмэгдэх тооцоо гарч байна.
4. Хувийн эмнэлгүүдэд урологийн тасгийн батлагдсан орны багтаамжийг 33.2 хувиар нэмэгдүүлж үйлчлүүлэгчдийг хэвтүүлэн эмчилж байна.
5. Өртөг ойролцоо оношийн бүлгээр санхүүжүүлэх арга нь тухайн бүлгийн өвчлөлүүдэд шаардлагатай хувьсах зардлыг тооцон санхүүжилт хийдэг арга. Хувийн болон улсын эмнэлгүүдийн алинд ч үйлчлүүлсэн тухайн өвчнийг нэг удаа хэвтүүлэн эмчлэхэд ижил зардал гардаг онцлогтой төлбөрийн арга юм. Гэтэл улсын болон хувийн эмнэлгүүдэд ялгаатай санхүүжилтээр санхүүжүүлснээр хувь хүний төлбөр өндөр эсвэл чанар муу, хямд эмнэлгийн хэрэгсэл ашиглах зэрэг сул тал гардаг байж болох юм.

Ашигласан материал, эх сурвалж:

Эрүүл мэндийн үзүүлэлт 2016 он, Эрүүл мэндийн хөгжлийн төв

Нийслэлийн эрүүл мэндийн статистик үзүүлэлт 2016 он, Нийслэлийн эрүүл мэндийн газар

Эрүүл мэндийн үзүүлэлтийн 1-р боть дэлгэрэнгүй, Эрүүл мэндийн хөгжлийн төв

Эрүүл мэндийн нийгмийн даатгал 2017 он, ЦГанцэцэг

www.ndaatgal.mn , www.mohs.mn , www.chd.mohs.mn , www.oecd.org